

**ДУНДАД ИРГЭН УЛСЫН ЭХЭН ҮЕ ДЭХ ГАДААД
МОНГОЛЫН ТУСГААР ТОГТНОЛ БА ӨВӨР МОНГОЛЫН
УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН ӨӨРЧЛӨЛТ**
/Товчлол/

*ХУАН ЛИШЭН**

Өвөр Монгол Мин улсын сүүлчээс эхлэн манж Чин улсад дагаар орохоос өмнө Чин улсын ноёрхлын газар нутагт багтаж байлаа. Гадаад Монгол Энх-Амгалан хааны 28-р онд /1691/ Чин улсын нутаг дэвсгэрт багтах болов. Өвөр Монгол, Ар Монгол урд хожид Дай Чин Улсын нутаг дэвсгэрт харьяалагдаж улмаар Хятадын тэнгэрийн хаанчлалын хүрээнд орсон юм. Хятадын тэнгэрийн хаанчлал гэдэг нь тэнгэрийн хувь заяагаар тэнгэрийн дор байгуулсан дэг журам бөгөөд Өвөр, Ар Монгол нь ийнхүү хятадын тэнгэрийн хаанчлалд багтаж Чин улсын төв удирдлагатай нягт холбогдож улмаар Хятадын шууд ноёрхлын харьяат нэгэн газар болсон юм.

Хятад улс хар тамхины дайны дараа өрнөдийн хүчирхэг улсуудын, капиталист ертөнц, эдийн засгийн системийн зах хязгаар орон болсноор Чин Улсын засгийн газар улс төр эдийн засгийн бүтцэндээ шинэчлэлт өөрчлөлт хийхээс аргагүй болж бүрэн эрхт улс ба, хууль эрх зүйт бүхий олон улсын нийгэмд татагдан орсон нь дотоод, гадаад Монголын ноёрхох байдалд нь ч нөлөөлсөн юм. Нөгөө талаар дэлхий нийтийн системд хагас хязгаар орон болж байсан Япон, Орос зэрэг орон хятадын хойд хязгаарт шинэ газар оронтой бололх гэж оролдож ялангуяа Орос улс Монгол Хятадын харилцааг сулруулахын тулд бүхий л аргаар оролдож байв. Гадаад дотоодын даралт шахалтын дор Чин Улс феодалын албан гувчуур татахыг гол болгосон Хятадын тэнгэрийн хаанчлалын системд өртөж аажмаар сулран доройтсоор Дундад Иргэн Улсын эхний жилүүдэд гадаад Монгол тусгаар тогтнож Өвөр Монголд улс төр эдийн засагт хувиралт өөрчлөлт гарахад хүргэв. Өвөр, Ар Монгол тухайн цагийн аясыг дагаж харилцан адилгүй байсан боловч, урьдын нэгэн адил харилцан хамааралтай, нэг нэгэндээ нөлөөлөх харилцаатай байлаа. Нөгөө талаар хятад улс дэлхийн системд эзлэх байр өөр байсан боловч Монгол үндэстэн дэлхийн системд нэгэн хүчин зүйл болж хоорондоо холбоотой диалетик харилцаатай байсан юм. 1858 оноос хойш хаант орос тэгш бүс гэрээ хэлэлцээрээр Гадаад Монголыг дэлхийн системийн зах хязгаар орон болгосон бөгөөд цагаагчин гахай жилийн хувьсгалаас хойш гадаад

* Хуан Лишэн - Тайваний Хайян Их сургуулийн түүхийн салбарын дэд профессор

Монгол нь Хятадаас салган тусгаарлах гэж оролдож Өвөр Монголын зарим ноёд Оросыг түшиж, Зүүн Монголд Манжийн шинэ Засгийн бодлогыг эсэргүүцсэн зэвсэгт тэмцэл гарч улмаар гадаад Монголын тусгаар тогтнох гэсэн тэмцэлд нь оролцсон юм. Цагаагчин гахай жилийн хувьсгалын дараа гадаад Монгол тусгаар тогтнож Өвөр Монголын ноёдыг нэгдэн нийлэхийг уриалсан юм. Өвөр Монголын ноёд үзэл санааны хувьд энэ уриалгыг дийлэнхи нь дэмжиж байсан боловч хэрэг дээрээ тусгаар тогтнолын төлөө цөөнх нь болж байв. гадаад Монгол хаант Оросын дэмжлэгтэй цэрэг хөдөлгөн зэвсгийн хүчээр Өвөр Монголчуудыг татах гэж бодож байв. Гэвч дундад иргэн улсын Засгийн газар тусгаар тогтнолын нөлөөллийг Өвөр Монголоос холдуулах, улмаар цагийн байдлыг харж гадаад Монголын тусгаар тогтнолыг аман дээрээ дэмжиж ачир дээрээ хязгаарлах Өвөр Монголыг Дундад иргэн улс ба Хаант Оростой гадаад Монголын асуудлаар харилцах гол өмөг түшиг болгохыг оролдож байв.

Гадаад Монгол Өвөр Монголын дэмжлэгийг олж чадалгүй, Хаант Орос гадаад Монголын талаарх бодлогоо түр зохицуулан өөрчилж “Хятад Орос Монголын хэлэлцээрт” гарын үсэг зурсны дараа түр хугацаагаар тусгаар тогтнол үгүй болсон боловч хэрэг дээрээ Хятадаас хол Оросод ойр байх хандлагад арга буюу шилжсэн юм. Өвөр Монгол нь Мин Чин улсын үеэс хойш Хятадтай эдийн засгийн нягт харилцаа хамааралтай явж ирсэн нь хэдийгээр гадаад Монголын тусгаар тогтнолд саад болсон ч улс төрийн тал дээр гадаад Монголтой адилгүйгээр үл барам гадаад Монголын нутаг дэвсгэрээс ангид байсны улмаас эдийн засаг нь их хэмжээгээр доройтож, улмаар гадаад Монголын эдийн засгийг ч доройтуулж Хятадын нийгмийн систем дэхь байр суурь нь хэвээр үлдэв. Өвөр, Ар Монгол нь хэдийгээр нэг үндэстэн, улмаар Хятадын тэнгэрийн хаанчлалаас Иргэн улсын системийн дотор нэг адил байсан боловч дэлхийн эдийн засгийн системд оролцох оролцоо байр суурь нь аажмаар ялгаатай болж нөлөөлөх нөлөөлөл нь өөр болж энэ нь өнөөг хүртэл хэвээр байгаа юм.

Хятад хэлнээс орчуулсан Л.Бэгзжав